



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/49

Мөрөн сум

Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Гишүүд: М.Алтаншагай	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга)
Г.Базар	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Б.Янжиндолгор	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)
Г.Ганням	(Аймгийн Цагдаагийн газрын Эдийн засгийн мөрдөгч Цагдаагийн ахмад)
Д.Содномдорж	(Хуульч)
Л.Пунсал-Орлом	(Мэргэшсэн нягтлан бодогч)
Нарийн бичгийн дарга: Г.Мөнхтулга	(Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга)

2. Дотоод аудитын хорооны хуралдааныг шаардлагатай үед шуурхай зохион байгуулан хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Дотоод аудитын хорооны нарийн бичгийн дарга (Г.Мөнхтулга)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны “Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/35 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын хорооны нарийн бичгийн дарга (Г.Мөнхтулга)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН